

ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2023

АГУУЛГА



1

БИДНИЙ ТУХАЙ

Эрхэм зорилго
Үнэт зүйлс
Алсын хараа
Уриа үг
Бидний тухай

2

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үйлдвэрлэл
Борлуулалт
Ашиг

3

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн ерөнхий мэдээлэл
Хувьцаа эзэмшигчид
Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хувьцааны мэдээлэл
Ногдол ашгийн мэдээлэл
Компанийн засаглалын
кодексийн хэрэгжилт
Гүйцэтгэх удирдлагын баг

4

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2022 оны эхний хагас жилийн
үйл ажиллагааны хураангуй
Бүтээн байгуулалт
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт

5

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН

Нийгэмд чиглэсэн ажил
Онцлох үйл явдлууд

01

БИДНИЙ
ТУХАЙ

ЭРХЭМ ЗОРИЛГО

ЭРҮҮЛ, ЭКОЛОГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭР
АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛНЭ.

ҮНЭТ ЗҮЙЛС



Өөртөө
болон
хэрэглэгчдэд
ТААШААЛ
өг



Хамтын
ажиллагаанд
ШУДАРГА
бай



Хүн
байгальд
ЭЭЛТЭЙ
бүтээ



Ажлаараа
ИТГЭЛ
төрүүл




Амжилтад
ХАМТ
хүр

АЛСЫН ХАРАА

ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭР
ДЭЛХИЙД ТЭРГҮҮЛНЭ.

УРИА ҮГ

ТҮМЭН ШУВУУТ®
Аз жаргалыг цйлдвэрлэнэ



Үйлдвэрлэлийн тоо хэмжээ /өндөг/
Сая ширхэг



Үйлдвэрлэлийн тоо хэмжээ /тэжээл/
Тонн



Үйлдвэрлэлийн тоо хэмжээ /цаасан үүр/
Сая ширхэг



Үйлдвэрлэлийн тоо хэмжээ /шингэн өндөг/
Мян.тонн



Нийт борлуулалт
Тэрбум төгрөг



Цэвэр ашиг
Тэрбум төгрөг



02

САНХҮҮГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА



ОЗ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Компанийн нэр:

Түмэн Шувуут ХК

Хэлбэр:

Нээлттэй Хувьцаат Компани

Регистрийн дугаар:

2844753

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:

Монголын хөрөнгийн бирж

МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал: **I**

Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг: **200 сая**

Бизнесийн үндсэн үйл ажиллагааны салбар:


- **Өндөгний үйлдвэрлэл**
- **Малын тэжээлийн үйлдвэрлэл**
- **Органик бордооны үйлдвэрлэл**
- **Цаасан үүр, сав баглаа боодлын үйлдвэрлэл**
- **Усалгаатай газар тариалан**
- **Мал аж ахуй**

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

➤ Хувьцаа эзэмшигчдийн тоо



➤ Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



■ Том хувьцаа эзэмшигч ■ Жижиг хувьцаа эзэмшигч

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнийг багцлан танилцуулсан хөрөнгө оруулалтын экспо-2023 арга хэмжээнд “Түмэн шувуут” ХК нь оролцож хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа зохион байгууллаа. Хурал 2023 оны 04-р сарын 29-нд Шангри -ла зочид буудал, 1-р давхрын боллрүүм 1 хурлын танхимд болов.

“Түмэн шувуут” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн, шийдвэрлэв.

1. “Түмэн шувуут” Хувьцаат компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах- Танилцуулгыг “Түмэн шувуут” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ж.Болд, Хөндлөнгийн аудитын дүгнэлтийг “Онч аудит” ХХК-ийн партнер Б.Анхтайван, ТУЗ-ийн дүгнэлтийг ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга А.Бакей нар мэдээлэл хийж, нийт хувьцаа эзэмшигч нарт танилцуулав.
2. "Түмэн шувуут" ХК 100% эзэмших “Агрофийд бордоо” ХХК-ийг үүсгэн байгуулах тухай тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргаж, шийдвэрийг батлуулав.
3. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулав.- ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр
 1. “Түмэн шувуут” ХК-ийн 2022 оны цэвэр ашгаас нийт хуваарилах ногдол ашиг: **2.1 тэрбум төгрөг**
 2. - Нэгж хувьцаанд – **10.7 төгрөг**
 3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн өдөр: **2023.04.11**
 4. Ногдол ашиг тарааж эхлэх хугацаа: **2023.09.30-ний өдрийн дотор/**
 5. Түмэн шувуут ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдийн тоо: **11,628** /2023 оны 04-р сарын 11-ны өдрийн байдлаар/



**ЛОМБЫН
ЭРХЭМБАЯР**
ТУЗ-ийн дарга
Мал зүйч-
үржүүлэгчдийн
холбооны тэргүүн,
“Түмэн Шувуут” ХК-
ийн үүсгэн байгуулагч
ХАА-н ухааны доктор
Ph.D
Хувьцаа эзэмшил:
30%



**БАЛАЙН
ТУНГАЛАГ**
ТУЗ-ийн ердийн гишүүн



**ЖИГЖИДИЙН
БОЛД**
ТУЗ-ийн ердийн гишүүн



**ЭРХЭМБАЯРЫН
БАЯРЖАРГАЛ**
ТУЗ-ийн ердийн гишүүн



**ЭРДЭНЭЧУЛУУНЫ
ЖАРГАЛХҮҮ**
ТУЗ-ийн ердийн гишүүн



**БОЛДБААТАРЫН
БАРХАСБАДЬ**
ТУЗ-ийн ердийн гишүүн




**АГИПАРЫН
БАКЕЙ**
ТУЗ-ийн хараат бус
гишүүн



**ЦЭДЭВИЙН
НАРАН-УЧРАЛ**
ТУЗ-ийн хараат бус гишүүн



**ГОЧООГИЙН
МӨНХ-ЭРДЭНЭ**
ТУЗ-ийн хараат бус
гишүүн



**ДАШЦЭРЭНГИЙН
НАРАНЦЭЦЭГ**
ТУЗ-ийн НБД

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

ТҮМЭН ШУВУУТ ХК-ийн гаргасан нийт хувьцаа **200,000,000**

Балансын үзүүлэлт	2023.II
Нийт хөрөнгө	65 771 852 050.72
Эргэлтийн хөрөнгө	31 561 495 893.36
Эргэлтийн бус хөрөнгө	34 210 356 157.36
Өр төлбөр	25 261 686 748.77
Эзэмшигчийн өмч	40 510 165 301.95


Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл

Нийт гаргасан ҮЦ	Том хувьцаа эзэмшигч			Жижиг хувьцаа эзэмшигч		
	ҮЦ-ны тоо ширхэг	Эзэмшигч ийн тоо	Эзлэх хувь	ҮЦ-ны тоо ширхэг	Эзэмшигч ийн тоо	Эзлэх хувь
200 000 000	160 035 855	4	80.02%	39 964 145	11 628	19,98%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны цэвэр ашгийн 30%-ийг Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилах шийдвэрийг 2023 оны 02-р сарын 11-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас нэгж хувьцаанд 10,7 төгрөг тараах шийдвэр гаргаж, тус оны 09-р сарын 30-ны өдрийн дотор “ҮЦТХТ” ХХКомпаниар дамжуулан тараахаар болсон. Мөн Голомт капитал ҮЦКомпани “Голомт кастодиан”-нд бүртгэлтэй хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг тус байгууллагын дансанд шилжүүлэх болно.

Жил	Нэгж хувьцаанд тараасан ашиг	Ногдол ашгийн өгөөж
2022	10.7	0.03%
2021	10.4	0.02%
2020	8	0.05%
2019	4.8	0.03%



➤ ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ



- ТУЗ нь 2023 оны эхний хагас жилийн хугацаанд нийт 4 удаа хуралдаж, үүнээс цахимаар 1 удаа, Биечлэн оролцсон 2 удаа, эчнээ хэлбэрээр 1 удаа хуралдаж, нийт 20 асуудалд үнэлэлт, дүгнэлт өгч, 13 шийдвэр гаргаж ажиллалаа.
 - 2023.02.11- 100%-ийн ирцтэй- 5 асуудал хэлэлцэж шийдвэрлэв.
 - 2023.03.18- 100%-ийн ирцтэй-3 асуудал хэлэлцэж шийдвэрлэв.
 - 2023.05.17-100%-ийн ирцтэй-2 асуудал хэлэлцэж шийдвэрлэв.
 - 2023.06.16-100%-ийн ирцтэй-3 асуудал хэлэлцэж шийдвэрлэв.
- ТУЗ нь компанийн засаглалын кодексийн зарчмыг хэрэгжүүлэх үүднээс Ногдол ашгийн бодлого болон Мэдээллийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн батлахаас гадна Цалин, урамшууллын бодлогыг боловсруулан шинээр баталлаа. Мөн комплайнсын ажилтан томилж, комплайнсын хяналтын зааврыг батлан мөрдөн ажиллаж байна.
- Компанийн засаглалын кодексийн өөрийн үнэлгээг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Наранцэцэг, компанийн дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтан Ж.Уянга, Хүний нөөцийн менежер Б.Нямбаяр нар гаргаж, нийт 67 оноо буюу 93,1%-ийн үнэлгээтэйгээр холбогдох байгууллага, хүмүүст танилцуулж ажиллалаа. КЗК-ийн хүрээнд тайлант жилд нэмэлтээр хийж гүйцэтгэх ажлуудыг 2023 оны ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх ажлын төлөвлөгөөнд оруулан тус оны 2-р хагаст хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

ТУЗ-ийн ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

- **НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО** онлайнаар 1 удаа хуралдаж 1 асуудал хэлэлцэж шийдвэрлэв.
 - Хорооны дарга хараат бус гишүүн Г.Мөнх-эрдэнэ,
 - Гишүүд-хараат бус гишүүн А.Бакей,
 - ердийн гишүүн Б.Бархасбадь
- **ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО** онлайнаар 2 удаа хуралдаж 2 асуудал хэлэлцэж шийдвэрлэв.
 - Хорооны дарга, хараат бус гишүүн Ц.Наран-Учрал,
 - Гишүүд- хараат бус гишүүн Г.Мөнх-Эрдэнэ,
 - ердийн гишүүн Б.Бархасбадь
- **АУДИТЫН ХОРОО** онлайнаар 1 удаа хуралдаж 1 асуудал хэлэлцэж шийдвэрлэв.
 - Хорооны дарга, хараат бус гишүүн А.Бакей,
 - Гишүүд- хараат бус гишүүн Ц.Наран-Учрал,
 - ердийн гишүүн Э.Баяржаргал,
- **ЁС ЗҮЙН ХОРОО** 1 удаа хуралдаж 1 асуудал хэлэлцэж шийдвэрлэв.
 - Хорооны дарга, хараат бус гишүүн А.Бакей,
 - Гишүүд- хараат бус гишүүн Г.Мөнх-эрдэнэ
 - ердийн гишүүн Б.Тунгалаг

Аудитын хороо



А.БАКЕЙ
/Дарга/



Ц.НАРАН-УЧРАЛ
/Гишүүн/



Э.БАЯРЖАРГАЛ
/Гишүүн/

Нэр дэвшүүлэх хороо



Г.МӨНХ-ЭРДЭНЭ
/Дарга/



Б.БАРХАСБАДЬ
/Гишүүн/



А.БАКЕЙ
/Гишүүн/

Цалин урамшууллын хороо



Ц.НАРАН-УЧРАЛ
/Дарга/



Г.МӨНХ-ЭРДЭНЭ
/Гишүүн/



Б.БАРХАСБАДЬ
/Гишүүн/

Ёс зүйн хороо



А.БАКЕЙ
/Дарга/



Г.МӨНХ-ЭРДЭНЭ
/Гишүүн/



Б.ТУНГАЛАГ
/Гишүүн/

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ, ЦААШИД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Санхүүгийн зохицуулах хорооноос “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталсны дагуу кодексын хэрэгжилтийг хангах зорилгоор “Түмэн шувуут” ХК-ийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж батлахаар дараах төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

Төлөвлөгөөний дагуу компанийн засаглалын баримт бичигтэй холбоотой дараах 16 бодлого, дүрэм журам, зааврыг үе шаттайгаар компанийн засаглалын Кодексийн зарчимд нийцүүлэн шинээр болон шинэчлэн батлах ажлыг төлөвлөн, хэрэгжүүлж байна.

№	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО, ДҮРЭМ ЖУРМУУДЫН НЭР	ОГНОО	ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН ЭСЭХ
1	Компанийн ёс зүйн дүрэм	2022 оны 11-р сарын 23	Хэлэлцэж баталсан
2	Залгамж халааны бодлого	2023 оны 09-р сарын 22	Боловсруулж байна.
3	Цалин, урамшууллын бодлого	2023 оны 02-р сарын 11	Хэлэлцэж баталсан
4	Ногдол ашгийн бодлого	2023 оны 02-р сарын 11	Шинэчлэн баталсан
5	Эрсдлийн удирдлагын заавар	2023 оны 09-р сарын 22	Боловсруулж байна.
6	Дотоод хяналтын тогтолцоо	2023 оны 09-р сарын 22	Боловсруулж байна.
7	Комплайнсын хяналтын заавар	2023 оны 02-р сарын 11	Хэлэлцэж баталсан
8	Тогтвортой хөгжлийн заавар	2023 оны 09-р сарын 22	Боловсруулж байна.
9	Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого	2023 оны 09-р сарын 22	Боловсруулж байна.
10	Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам	2019 оны 05-р сарын 15	Хэлэлцэж баталсан
11	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам /ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам	2019 оны 05-р сарын 15	Хэлэлцэж баталсан
12	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам	2023 оны 09-р сарын 22	Боловсруулж байна.
13	Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам	2023 оны 02-р сарын 11	Шинэчлэн баталсан
14	Дотоод хяналт, комплайнс, дотоод аудитын нэгж эсхүл ажилтны үйл ажиллагааны журам	2023 оны 01-р сарын 02	ГЗ-ын тушаалаар баталсан
15	Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам	2019 оны 05-р сарын 15	Хэлэлцэж баталсан
16	Ёс зүйн хорооны үйл ажиллагааны журам	2022 оны 11-р сарын 23	Хэлэлцэж баталсан

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



**ЖИГЖИД
БОЛД**
Гүйцэтгэх захирал



**ЭРХЭМБАЯР
БАЯРЖАРГАЛ**
Дэд захирал



**ЖАРГАЛСАЙХАН
УЯНГА**
Эдийн засагч



**БАЛАА
УНДРАХ**
Усжуулах ХК-ийн Захирал



**БӨХЦЭВЭЭН
МӨНГӨНТУЯА**
Борлуулалтын албаны дарга



**НАЙМАНЖИН
ДОЛЖИНСҮРЭН**
Ерөнхий нягтлан бодогч



**ЧУЛУУНБААТАР
НОМИН-ЭРДЭНЭ**
Шууу аж ахуй-1 дарга



**ДАРАМБАЗАР
БАЯНМӨНХ**
Шууу аж ахуй-2 дарга



**ЦЭДЭН-ИШ
ОЮУНГЭРЭЛ**
Тэжээлийн үйлдвэрийн дарга



**ЖАВХЛАН
ЦОГТ**
Сав баглааны үйлдвэрийн Захирал

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Ашиглалтад орсон:
Өндөглөгчийн
1, 2, 3, 4, 5-р байр,
Дэгдээхэйн **1-р** байр



Барилга, угсралтын
ажил хийгдэж байгаа:
6, 7, 8-р байр
Дэгдээхэйн **2-р** байр



04

БИЗНЕСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

ISO ЭРҮҮЛ МЭНДИЙН БАГЦ

Хүний эрүүл мэндэд онцгой ач холбогдолтой Иод, Селен, Омега-3-тай өндгийг манай компани хэрэглэгчдэдээ нийлүүлж байна.

Иод, селен, Омега-3-тай өндөгний онцлог нь өндөглөгч тахианы тэжээлд уг элементийг нэмэлтээр хийж агууламжийг нэмэгдүүлснээр Монгол хүний биед утагдаж буй иод, селен, Омега-3-ыг нөхөх боломжтой болж буй юм.

Хүний цусны ийлдсэнд агуулагдах селений зохимжит дундаж хэмжээ 110-120 мкг/л байдаг бол монгол хүнийх 61.62 мкг/л хэмжээтэй болохыг НЭМХүрээлэнгийн судалгаа харуулсан.

ОМЕГА-3 ӨНДӨГ ЭРГЭН ИРЛЭЭ


Омега-3-тай өндөгний онцлог нь өндөглөгч тахианы тэжээлд омега нэмэлтээр хийж баяжуулснаар тархи, оюун ухааны хөгжилд сайнаар нөлөөлөх, зүрхний үйл ажиллагааг дэмжих, сэтгэл хямралд өртөх, нойргүйдэхээс таныг хамгаалдаг сайн талтай.



БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ



100% ОРГАНИК КОМПОСТ ШИНГЭН БАКТЕРИЙН БОРДОО



Шувууны сангасаар дэлхийд тэргүүлэх Япон технологиор байгаль орчинд ээлтэй 100% органик компост бордооны үйлдвэрийг 2019 онд ашиглалтад оруулж жилд 2000-2500тонн бордоог зах зээлд нийлүүлж байна.

Компост бордооны
найрлага →

Үзүүлэлт	
pH	6.0-7.5%
Кали	2.5-3.0%
Азот	2.5-4.2%
Фосфор	2.5-4.0%



Зөвхөн шувууны сангас, модны үртэс буюу модлог ургамал.



Ямар нэгэн химийн нэмэлтгүй тул хөрс бактериар бохирдохгүй.

АЮУЛГҮЙ, НАЙДВАРТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН

Компостер нь сангасыг өдөрт 1-2 удаа хутгаж өгсөнөөр агаар оруулж боловсруулалтыг хурдасгана. Микро организмуудын үйл ажиллагааны үр дүнд 60° -70° дулааныг ялгаруулна. Сангасыг 40 гаруй хоног 70° -75° -ын температурт боловсруулсанаар сангасанд агуулагдах сальмонеллез, E-коли зэрэг хорт бактерийг бүрэн устгаж өгнө.

05

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН

Хагас жилийн тайлан 2023 •

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ ХҮЧИН ЗҮЙЛИЙГ БАГАСГАХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

ХАЯГДАЛ ЦААС ДАХИН БОЛОВСРУУЛАХ

Иргэд, харилцагчдаас хаягдал цаасыг үнэлэн худалдан авч өндөгний цаасан үүр үйлдвэрлэж байна. Уг ажлын хүрээнд нийт 135 тн хаягдал цаасыг ашиглаж 1,667,500 ширхэг цаасан үүр үйлдвэрлэжээ.

ХАЯГДАЛ БОР ЦААС ИХ ХЭМЖЭЭГЭЭР
БАЙНГА ХУДАЛДАЖ АВНА

1 кг 70₮



ХАВТАСГҮЙ, ҮДЭЭСГҮЙ, СКОЧГҮЙ, ШОХОЙГҮЙ,
НААЛТГҮЙ БАЙХ ШААРДЛАГАТАЙ



ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД:

ХУВЬЦААТАЙ АЖИЛТАН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ



“Түмэн шувуут” ХК-ийн нийт ажилчдын 50 гаруй хувь нь өөрийн компаний хувьцааг эзэмшдэг бөгөөд компани ажилчидаа хувьцаажуулах хөтөлбөрийг тасралтгүй 4 дэх жилдээ хэрэгжүүлж байна. Энэ нь тухайн ажилтны сар бүрийн цалин дээр хувьцаа худалдан авах тодорхой хэмжээний мөнгийг байгууллагаас олгодог урамшуулалт хөтөлбөр юм. 2023 оны эхний хагас жилийн хугацаанд нийт 100 гаруй ажилтанд 43,484 ширхэг хувьцааг авч өглөө. Мөн компанийнхаа хувьцаа эзэмшигч болохоор хүсэлтээ өгсөн 35 ажилтанд данс нээж хувьцаатай ажилтан хөтөлбөрт хамрууллаа.

ХЭРЭГЛЭГЧИЙГ ДЭМЖИХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:



“УХААЛАГ, ХЭМНЭЛТТЭЙ СОНГОЛТ” УРИАЛГАД НЭГДЭЦГЭЭ

Байгаль орчноо хайрлахад бидний ухаалаг сонголт хамгийн чухал. Шошгоны зардлыг бууруулж, хэмнэлтийг хэрэглэгч ТАНД уриатайгаар ШОШГОГҮЙ савлагаатай ӨНДӨГ худалдаанд гаргав.

Судалгаагаар хэрэглэгчид бүтээгдэхүүн дээрх шошгоны мэдээллийг гол төлөв гар утаснаасаа авчигдах гэсэн дүн байдаг тул өөрийн вэб сайтад шошгоны мэдээллийг байршуулж, QR код уншуулах зориулалттайгаар уг бүтээгдэхүүнийг худалдаанд гаргав.

ХЭРЭГЛЭГЧИЙГ ДЭМЖИХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:



“НАДАД АСУУЛТ БАЙНА, АХ, ЭГЧ НАРАА” ЗОРИЛТОТ КОНТЕНТ

Хэрэглэгчид болон харилцагч, хувьцаа эзэмшигч нарт зориулан өндөгний тухай мэдлэг олгох видео контент бэлтгэн өөрийн алабн ёсны Facebook page хуудсаар дамжуулан хүргэж байна.

“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ТАЙ ТАНИЛЦАХ АЯЛАЛ



Хэрэглэгчдийг өндөгний талаар бодит мэдээллээр хангах, өндөг нь хэрэглэгчийн гар дээр хүрэх хүртлээ хэчнээн дамжлага дамждагийг танилцуулах, хүүхдүүдэд танин мэдэхүй, хөдөлмөрийг хүндлэх боловсрол олгох зорилгоор танилцах аялалыг зохион байгуулав.

“Хөтөлбөрт 13-аас дээш насны, 20-45 хүний бүрэлдэхүүнтэй баг хамт олныг долоо хоног бүрийн Бямба гарагийн 10:00 цагт хуваарийн дагуу үйлдвэртэй танилцууллаа. Нийт 250 орчим иргэд, хүүхдүүд хамрагдлаа.

“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАХ АЯЛАЛ

ШУВУУНЫ АЖ АХУЙ-1

“Хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 13-аас дээш насны, 20-45 хүний бүрэлдэхүүнтэй баг хамт олныг долоо хоног бүрийн Бямба гарагийн 11:00 цагт хуваарийн дагуу үйлдвэртэй танилцах аялалд урьж байна.

АЯЛАГЧИД АНХААРАХ ЗҮЙЛС:

- Аялагчид 7000-5225 (1) дугаарт урьдчилж бүртгүүлсэн байна.
- Унааг аялагч өөрөө хариуцна.
- Аялагчид 10:30 минутад Түмэн Шувуут-1 дээр ирсэн байх. /хоцорч болохгүй/
- Аялал 11:00 цагт эхэлнэ.
- Аялагчдад жүүс, кофе, цай, аяган кек, өндгөөр дайлна.
- Насны хязгаар 13-с дээш

ХАЯГ:
Хан-Уул дүүрэг 13-р хороо, Шувуун фабрик, туул тосгон, Түмэн-Шувуут-1 шувууны аж ахуй.

БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР СУРАЛЦАЖ БАЙГАА ОЮУТНУУДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ОЛИМПИАДЫГ САНХҮҮЖҮҮЛЛЭЭ.

Түмэн шувуут ХК нь Монголын Санхүүгийн шинжээчдийн нийгэмлэгээс санаачлан жил бүр зохион байгуулдаг CFA Institute Research Challenge тэмцээнийг ивээн тэтгэж оролцлоо. Энэ удаагийн тэмцээнд ялсан баг Ази Номхон Далайн бүсийн тэмцээнд өрсөлдөх эрх авсан бөгөөд уг тэмцээн нь Монгол улсад 2017 оноос хойш 7 дахь жилдээ зохион байгуулагдаж байна.

- МУИС-ын "SIRIUS" баг тэмцээнд ялалт байгуулж Нэгдүгээр байр,
- Хоёрдугаар байрыг Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн “Шар шувуунууд” баг
- Гуравдугаар байрыг МУИС-ийн “Meta Genius” баг тус тус хүртлээ.

Оролцсон бүх багууд CFA Институтийн сүлжээгээр дамжуулан санхүүгийн шинжилгээ, мэргэжлийн ёс зүйн эрчимжүүлсэн сургалт, тэдний багш зөвлөх, салбарын ментороор дамжуулан сургалт авсан юм.



НИЙГЭМ, ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭСЭН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛАВ.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийслэлд эрчимжсэн аж ахуйг кластер байдлаар төрөлжүүлэн хөгжүүлнэ гэж заасан ажлын хүрээнд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар “Түмэн шувуут” ХК-тай хамтран ажиллах Санамж бичиг байгуулав.

Ингэснээр талууд хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар төрөөс баримталж буй бодлогын хүрээнд хот орчмын мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бүсэд өндөр ашиг шимтэй, түргэн өсөлттэй эрчимжсэн мал аж ахуйн төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах юм.

Санамж бичигт “Түмэн шувуут” ХК нийгмийн хариуцлагынхаа хүрээнд эрүүл хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний ач тусыг сурталчлан таниулах зорилгоор жилд 9000 сурагчийг хүлээн авч, танилцах аялал зохион байгуулах хүчин чадал бүхий Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төв байгуулна гэж тусгасан. Ингэснээр ерөнхий боловсролын сургуулийн сурагч, оюутан залууст экологийн боловсрол олгож, амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх боломж бүрдэх юм.

Санамж бичгийн хүрээнд хот орчмын доройтсон бэлчээрийг нөхөн сэргээж, харшилд гол нөлөө үзүүлж буй лууль, шарилжийн бэлчээрт эзлэх хувь хэмжээг бууруулах технологийг боловсруулан, хэрэгжүүлэхээр болсон.



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭСРЭГ БОДЛОГЫН ХҮРЭЭНД: НОГООН БАЙГУУЛАМЖ, ЗҮЛЭГЖҮҮЛЭЛТ ХИЙХ, МОД ТАРИХ, НОГООН ЗУРВАС БАЙГУУЛАХ

Түмэн шувуут-2 аж ахуй /СХД-ийн 21-р хороо Их булаг/



“Түмэн шувуут” ХК нь шинээр байгуулж байгаа “Түмэн шувуут-2” шувууны аж ахуйн бүтээн байгуулалтын ажлын нэг хэсэг болгож хамгаалалтын зурвас буюу үйлдвэрийн эзэмшлийн 20000 м/2 газрыг тойруулан нийтдээ 1600 ширхэг улиас модыг тарьж 98%-ийн ургалттай, 1000м/2 талбайд зүлэгжүүлэлтийн ажлыг хийгээд байна.

Түмэн шувуут-1 аж ахуй /ХУД-ийн 13-р хороо Туул тосгон/



Мөн Хан-Уул дүүргийн 13-р хороо Туул тосгоны нийтийн эзэмшлийн зам талбайд буюу “Түмэн шувуут-1” аж ахуйн эргэн тойронд 3600 м/2 талбайд ногоон байгууламж, зүлэгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгээд байна.



Тэжээлийн үйлдвэр /СХД-ийн 21-р хороо Рашаант өртөө/

Тэжээлийн үйлдвэрийн эзэмшлийн талбайд 400 м/2 газарт ногоон байгууламж, зүлэгжүүлэлт, хамгаалалтын зурвас бүхий 400 ширхэг улиас мод, 2600 м/2 газарт нөхөн сэргээлтийн зүлэгжүүлэлт, 20 га талбайд ногоон тэжээл тариалах ажлуудыг тус тус хийж гүйцэтгээд байна.



БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ ХҮЧИН ЗҮЙЛИЙН НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

ОРГАНИК ХӨГЖИЛ ХАМТЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН “ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА”-ЫН ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЖ АЖИЛЛАЛАА



“Түмэн шувуут” ХК нь органик бордооны үйлдвэрлэлийнхээ хүрээнд Органик хөгжил Хамтын Баталгаажуулалтын Байгууллагын гишүүн байгууллага байх эрхээ 2021 онд авсан бөгөөд түүнээс хойш тус байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож органик тариалалт, компост бордоо үйлдвэрлэлийн чиглэлээр судалгаа, практик туршлага хослуулан хэрэгжүүлэгч байгууллага, хувь хүмүүсийн ажил үйлчилгээг дэмжихэд өөрийн хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Тус хамтын баталгаажуулалтын байгууллага нь гишүүн үйлдвэрлэгчийнхээ органик бүтээгдэхүүнийг жил бүр очиж магадлан баталгаажуулж, органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд аудит хийж ажилладаг.



Гишүүн байгууллагууд органик баталгаажуулалт хийлгэснээсээ хойш жил бүр магадлан баталгаажуулалт хийгэдэг бөгөөд өнгөрсөн хугацаанд Гэр гарден-Органик ХХК-ийн Саладны навч, Улаан лооль, Брокли, Хүрэн манжин, Чинцай, Өргөст хэмх зэрэг хүнсний ногоог магадлан баталгаажууллаа. Баталгаажуулалтын ажилд ХББ-ын гишүүд: Л.Энхтуяа- Урбан фермер Urban farmer, Б.Мөнгөтуяа- Түмэн шувуут ХК-ийн 100% Компост Бордоо, Б.Нарангарав-Амгаланзаяа ЭУ- 100% монгол орны ургамал 100% монгол орны ургамал, Ш.Будсүрэн-FARM Market – нарны хороолол, ХААИС доктор Ж. Оюунгэрэл, ХААИС-ын докторант Ц.Болорхундага, УХЭШХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан А.Уранчимэг, Л.Баянзул нар оролцов.



Хагас жилийн тайлан 2023

ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД:

- **ГАНЗОРИГ БИЗНЕС СУРГУУЛЬ**- Энергийн менежмент- 50 ажилтан 4 цагийн сургалт, Манлайллын менежмент-30 ажилтан 2 цагийн сургалт, Харилцагчийн үйлчилгээ- 20 ажилтан-2 цагийн сургалт, Өндөр бүтээмжтэй борлуулагчийн ур чадвар-15 ажилтан 2 цагийн сургалт,

- **АЛТАН ЧАДАМЖ СУРГАЛТЫН ТӨВ**- Сэрээт ачигчийн оператор - 4 ажилтан 4 цагийн сургалт

- **МОНГОЛ ЯПОНЫ ХӨГЖЛИЙН ТӨВ**- 5S хөдөлгөөнийг хэрэгжүүлэх нь- 150 ажилтан-16 цагийн сургалт




СУРГАЛТ ХӨГЖҮҮЛЭЛТЙН АЖЛУУД

- **ХҮНИЙ НӨӨЦИЙН НЭГЖ**- PAINT TIME- уран зургийн сургалт-25 хүн 3 цагийн сургалт

- **МҮХАҮТ-ын дэргэдэх БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙН ТӨВ** - Комплайнс, эрсдэлийн удирдлага” сургалт 2 хүн-3 цаг

- **СТАНДАРТ ХЭМЖИЛЗҮЙН ГАЗАР**- Чанарын менежментийн тогтолцооны дотоод аудиторын сургалт-1 хүн-8 цагийн сургалт, Байгаль орчны менежментийн тогтолцооны сургалт -3 хүн- 8 цагийн сургалт



Хагас жилийн тайлан 2023

ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД:

-ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГ- Татварын мэргэшүүлэх сургалт-3 хүн 10 кредит цаг буюу 300 цагийн сургалт

-UPDATE НЯГТЛАН, НЯРАВЫН СУРГАЛТЫН ТӨВ- Няравын мэргэшүүлэх сургалт-2 хүн 48 цагийн сургалт

- УЛААН ЗАГАЛМАЙН НИЙГЭМЛЭГ- Анхан шатны тусламжийн сургалт- 120 хүн- 3 цагийн сургалт



СУРГАЛТ ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖЛУУД

- ECA ACADEMY – Гэрэл зургийн сургалт -1 хүн 12 цагийн сургалт, Бүтээгдэхүүний зураг авалт- 1 хүн 8 цагийн сургалт

-БНХАУ-ын мэргэжилтэн -Шувууны аж ахуйн технологийн сургалт-25 хүн 16 цагийн сургалт

-БНХАУ-ын мэргэжилтэн -Инженер техникийн ажилтнуудын сургалт- 10 хүн – 4 цагийн сургалт

- ЖАЙКА ОУ-ЫН БАЙГУУЛЛАГА, ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ, DRUB төвөөс зохион байгуулсан ААНБ-уудад зориулсан 8 дахь удаагийн нөлөөллийн сургалт-2 хүн 8 цагийн сургалт

НИЙТ 464 ХҮН 451 ЦАГИЙН СУРГАЛТАНД ХАМРАГДАЖ ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЖЭЭ.





**АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТАНД
БАЯРЛАЛАА**